



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Хөгжимт драмын театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2025/101/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2025 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954 Цахим хаяг: Aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Ш.Нурлан

Утас: 99422966 Цахим хаяг: nurlansh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

60129 Өлгий, Баян-Өлгий аймаг
Утас/Факс: (976) 7042 2054
E-mail: bayanugi@audit.gov.mn

ХӨГЖИМТ ДРАМЫН ТЕАТРЫН
ДАРГА Ж.САЙГҮЛИК
ТАНАА

2025.02.12 № 32
танай _____ -ны № _____ -Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөгжимт драмын театрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөгжимт драмын театр нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

Аудитын гол асуудал

Хөгжимт драмын театрын үндсэн хөрөнгийн түүхт соёлын дурсгалт зүйл дансанд 1115 нэр төрлийн нийт 73.6 сая төгрөгийн элэгдэж хуучирсан, ашиглах боломжгүй болсон хувцас хэрэглэлийг бүртгэж, тайлагнаж ирсэн бөгөөд эдгээр хөрөнгүүдийг акталж данснаас хасах асуудлыг шийдвэрлээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>174,982,976.67</u>	<u>172,509,896</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	32,182,332.67	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31110	Төгрөг	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	32,182,332.67	-
3121	Төгрөг	32,182,332.67	-
31211	Төрийн сангийн харилцах	32,142,332.67	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	40,000.00	-
33	АВЛАГА	1,500,000.00	-
335	Бусад авлага	1,500,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	1,500,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	141,300,644.00	172,509,896
354	Хангамжийн материал	141,300,644.00	172,509,896
35410	Бичиг хэргийн материал	264,500.00	521,500
35420	Аж ахуйн материал	62,775,994.00	60,023,296
35430	Сэлбэг хэрэгсэл	952,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	77,308,150.00	111,965,100
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,754,151,190.79</u>	<u>5,923,352,043</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,754,151,190.79	5,923,352,043
392	Биет хөрөнгө	5,599,816,555.03	5,768,534,051
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,382,873,700.96	6,682,873,701
39202	Хуримтлагдсан элэгдэл	(936,259,050.60)	(1,125,034,382)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	209,104,078.00	273,631,235
39206	Хуримтлагдсан элэгдэл	(165,379,224.44)	(191,447,034)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	187,794,149.00	129,776,384
39208	Хуримтлагдсан элэгдэл	(167,160,099.12)	(86,477,854)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	73,609,568.00	73,609,568
39214	Бусад үндсэн хөрөнгө	131,275,213.20	85,977,056
39215	Хуримтлагдсан элэгдэл	(116,041,779.97)	(74,374,623)
393	Биет бус хөрөнгө	154,334,635.76	154,817,993
39301	Програм хангамж	3,498,239.00	3,498,239
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,068,603.24)	(1,799,413)
39303	Бусад биет бус хөрөнгө	151,905,000.00	153,145,000
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(25,833)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,929,134,167.46</u>	<u>6,095,861,939</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>270,327,866.00</u>	<u>270,327,866</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	270,327,866.00	270,327,866
413	Өглөг	270,327,866.00	270,327,866

Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

4136	Бусад өглөг	270,327,866.00	270,327,866
41361	Байгууллагад төлөх өглөг	270,327,866.00	270,327,866
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,658,806,301.46</u>	<u>5,825,534,073</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,658,806,301.46	5,825,534,073
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,055,006,814.00	1,055,006,814
51101	Өмч: - төрийн	1,055,006,814.00	1,055,006,814
512	Хуримтлагдсан үр дүн	(1,634,481,810.42)	(1,463,254,039)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,400,556,747.43)	(1,629,981,810)
51220	Тайлант үеийн үр дүн	(233,925,062.99)	166,727,772
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,238,281,297.88	6,233,781,298
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5,929,134,167.46</u>	<u>6,095,861,939</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,240,494,333.39	3,222,836,595.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	84,735,039.00	420,853,225.00
120	Нийтлэг татварын бус орлого	84,735,039.00	420,853,225.00
120004	Т	78,955,800.00	64,666,800.00
1200041	өсөвт байгууллагын өөрийн орлого Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	72,955,800.00	64,666,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,000,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	5,779,239.00	356,186,425.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,155,759,294.39	2,801,983,370.51
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,694,769,694.39	2,166,464,554.51
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,694,769,694.39	2,166,464,554.51
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,540,000.00	10,865,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	6,975,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,650,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	540,000.00	240,000.00
131106	Төсвийн урамшуулал	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	457,449,600.00	624,653,816.00

Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	417,649,600.00	624,653,816.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	39,800,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,474,419,396.38	3,056,108,823.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,474,419,396.38	3,056,108,823.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,248,747,896.38	2,950,272,548.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,228,614,280.72	1,747,238,800.00
210101	Үндсэн цалин	778,938,032.72	1,087,849,382.00
210102	Нэмэгдэл	206,474,059.00	448,038,940.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	67,137,400.00	68,064,800.00
210104	Урамшуулал	176,064,789.00	143,285,678.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	154,550,557.00	218,404,800.00
210201	Тэтгэврийн даатгал	105,413,588.00	148,515,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,401,627.00	17,472,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,864,046.00	8,736,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,442,885.00	8,736,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,428,411.00	34,944,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	545,238,022.00	620,794,736.00
210301	Гэрэл, цахилгаан	11,221,000.00	14,322,436.00
210302	Түлш, халаалт	521,905,022.00	592,360,300.00
210303	Цэвэр, бохир ус	12,112,000.00	14,112,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,549,750.00	20,249,360.00
210401	Бичиг хэрэг	1,366,000.00	6,943,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,063,200.00	4,026,560.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	770,550.00	1,119,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,350,000.00	8,160,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,496,400.00	50,788,380.00
210604	Урсгал засвар	19,496,400.00	50,788,380.00
2107	Томилолт, зочны зардал	4,759,600.00	14,338,800.00
210702	Дотоод албан томилолт	4,759,600.00	14,338,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,401,800.00	26,628,812.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,668,800.00	25,828,812.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	149,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	430,000.00	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	248,137,486.66	251,828,860.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,110,700.00	27,429,588.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	467,900.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	235,558,886.66	224,399,272.56
210904	Найдваргүй авлагын алдагдал	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	225,671,500.00	105,836,275.18

Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	225,671,500.00	76,491,306.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,621,300.00	7,100,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	61,753,306.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	215,282,200.00	7,638,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	29,344,969.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	29,344,969.18
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(233,925,062.99)	166,727,771.77
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(233,925,062.99)	166,727,771.77

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,193,415,094.39	2,868,150,170.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	77,455,800.00	66,166,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	77,455,800.00	66,166,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	77,455,800.00	66,166,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	71,455,800.00	66,166,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,000,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,115,959,294.39	2,801,983,370.51
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,694,769,694.39	2,166,464,554.51
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,694,769,694.39	2,166,464,554.51
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,540,000.00	10,865,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	6,975,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,650,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	540,000.00	240,000.00
131106	Төсвийн урамшуулал		

Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	417,649,600.00	624,653,816.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	417,649,600.00	624,653,816.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,131,096,137.72</u>	<u>2,862,918,803.18</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,131,096,137.72	2,862,918,803.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,905,424,637.72	2,757,082,528.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,228,614,280.72	1,747,238,800.00
210101	Үндсэн цалин	778,938,032.72	1,087,849,382.00
210102	Нэмэгдэл	206,474,059.00	448,038,940.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	67,137,400.00	68,064,800.00
210104	Урамшуулал	176,064,789.00	143,285,678.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	154,550,557.00	218,404,800.00
210201	Тэтгэврийн даатгал	105,413,588.00	148,515,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,401,627.00	17,472,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,864,046.00	8,736,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,442,885.00	8,736,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,428,411.00	34,944,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	413,649,600.00	620,794,736.00
210301	Гэрэл, цахилгаан	11,221,000.00	14,322,436.00
210302	Түлш, халаалт	390,316,600.00	592,360,300.00
210303	Цэвэр, бохир ус	12,112,000.00	14,112,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,683,750.00	19,546,360.00
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	7,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,063,200.00	4,026,560.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	770,550.00	1,119,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,350,000.00	7,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,153,400.00	52,954,880.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		423,500.00
210604	Урсгал засвар	20,153,400.00	52,531,380.00
2107	Томилолт, зочны зардал	4,759,600.00	14,338,800.00
210702	Дотоод албан томилолт	4,759,600.00	14,338,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,699,400.00	70,061,352.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	62,966,400.00	69,261,352.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	149,000.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	430,000.00	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,314,050.00	13,742,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,462,000.00	13,742,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	852,050.00	

Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	225,671,500.00	105,836,275.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	225,671,500.00	76,491,306.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,621,300.00	7,100,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		61,753,306.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	215,282,200.00	7,638,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	29,344,969.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		29,344,969.18
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>62,318,956.67</u>	<u>5,231,367.33</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	31,186,800.00	37,413,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31,186,800.00	37,413,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	31,186,800.00	37,413,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	31,186,800.00	37,413,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(31,186,800.00)</u>	<u>(37,413,700.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
250005	Төлсөн ногдол ашиг		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	31,132,156.67	(32,182,332.67)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,050,176.00	32,182,332.67
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	32,182,332.67	

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	/ төгрөгөөр / Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,055,006,814.00	6,238,281,297.88	-1,400,556,747.43		5,892,731,364.45

Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,055,006,814.00	6,238,281,297.88	-1,400,556,747.43	0.00	5,892,731,364.45
Тайлант үеийн үр дүн			-233,925,062.99		-233,925,062.99
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,055,006,814.00	6,238,281,297.88	-1,634,481,810.42	0.00	5,658,806,301.46
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,055,006,814.00	6,238,281,297.88	-1,634,481,810.42	0.00	5,658,806,301.46
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			4,500,000.00		4,500,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,055,006,814.00	6,238,281,297.88	-1,629,981,810.42	0.00	5,663,306,301.46
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-4,500,000.00			-4,500,000.00
Тайлант үеийн үр дүн			166,727,771.77		166,727,771.77
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,055,006,814.00	6,233,781,297.88	-1,463,254,038.65	0.00	5,825,534,073.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,888,404,400	2,870,707,534
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,888,404,400	2,870,707,534
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,810,732,900	2,794,216,228
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,747,238,800	1,747,238,800
210101	Үндсэн цалин	1,089,885,000	1,087,849,382
210102	Нэмэгдэл	446,672,700	448,038,940
210103	Унаа хоолны хөнгөлөлт	71,628,000	68,064,800
210104	Урамшуулал	139,053,100	143,285,678

Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	218,404,800	218,404,800
210201	Тэтгэврийн даатгал	148,515,300	148,515,300
210202	Тэтгэмжийн даатгал	17,472,400	17,472,400
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,736,200	8,736,200
210204	Ажилгүйдлийн даатгал	8,736,200	8,736,200
210205	Эрүүл мэндийн даатгал	34,944,700	34,944,700
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	623,650,400	620,794,736
210301	Гэрэл, цахилгаан	17,178,100	14,322,436
210302	Түлш, халаалт	592,360,300	592,360,300
210303	Цэвэр, бохир ус	14,112,000	14,112,000
2104	Хангамж, бараа материалын зардал	26,000,000	19,546,360
210401	Бичиг хэрэг	7,200,000	7,200,000
210402	Тээвэр, шатахуун	10,200,000	4,026,560
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,400,000	1,119,800
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,200,000	7,200,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	88,034,100	86,812,580
210601	Багаж, техник, хэрэгсэл	34,861,200	34,281,200
210604	Урсгал засвар	53,172,900	52,531,380
2107	Томилолт, зочны зардал	14,700,000	14,338,800
210702	Дотоод албан томилолт	14,700,000	14,338,800
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	78,650,000	73,337,352
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	76,572,000	72,537,352
210803	Даатгалын үйлчилгээ	282,500	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	188,500	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	187,000	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,420,000	800,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,054,800	13,742,800
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,054,800	13,742,800
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,671,500	76,491,306
2132	Бусад урсгал шилжүүлэг	77,671,500	76,491,306
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,085,400	7,100,000
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	61,880,100	61,753,306
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,638,000	7,638,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	68,000	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,871,407,355	2,900,052,503

Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,166,464,555	2,166,464,555
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,166,464,555	2,166,464,555
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	628,151,000	624,653,816
122005	Орон нутгийн төсвөөс	628,151,000	624,653,816
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	76,791,800	76,791,800
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	76,791,800	76,791,800
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	32,142,333
145005	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх		32,142,333
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	145	147
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	71	73
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	57	59
620003	Үйлчлэх ажилтан	13	13
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	73	73
650006	Соёл урлагийн салбарын төрийн йлчилгээний албан хаагч (ТҮСУ)	60	60
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13	13

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

			НТ-2
			/ төгрөгөөр /
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,540,000.00	280,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,540,000.00	280,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,540,000.00	280,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	280,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		280,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	540,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	540,000.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,540,000.00	240,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,540,000.00	240,000.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	540,000.00	240,000.00
131106	Төсвийн урамшуулал		
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	40,000.00	40,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	40,000.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Хөгжимт драмын театр нь жүжиг, хөгжим бусад урлагийн үйл ажиллагаа явуулдаг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Аймгийн Хөгжимт драмын театрын тайлант оны зорилгыг “Үндэсний уламжлалт болон орчин үеийн соёл урлагийг хөгжүүлэх, хүн төрөлхтний бүтээн бий болгосон соёлын биет ба биет бус өв, ёс заншлыг ард иргэдэд хүргэх, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж улмаар өөрийн зах зээлтэй болох зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Уран бүтээлчдийн дотоод бүтцийг оновчтой зохион байгуулж, 100 хувь мэргэшсэн урлагийн нэгдмэл чадварлаг баг хамт олон бүрдүүлнэ.
- Урлаг, соёлын сайн менежменттэй өндөр зэрэглэлийн театр болохыг эрмэлзэнэ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Хөгжимт драмын театр нь Соёлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Хөгжимт драмын театрын 2024 онд санхүүгийн үйл ажиллагаанд ямар нэгэн шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр

Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөгжимт драмын театрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Хөгжимт драмын театрын даргын 2020 оны 03 сарын 30-ны өдрийн А/17 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөгжимт драмын театр 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	32,182.3	0	-32,182.3
Авлага	1,500.0	810,2	-689.8
Урьдчилгаа	-	-	
Бараа материал	141,300.7	172,509.9	31,209.2
Үндсэн хөрөнгө	5,754,151.2	5,923,352.0	169,200.8
Нийт хөрөнгө	5,929,134.1	6,096,672.0	167,537.9
Өр төлбөр	270,327.9	270,327.9	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,658,806.3	5,826,344.2	167,537.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,929,134.2	6,096,672.0	167,537.8

Дээрх хүснэгтээс харахад дараах өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна. Авлагын дансны үлдэгдэл 0.7 сая төгрөг болж буурсан нь түрээсийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 172.5 сая төгрөг болж 31.2 сая төгрөгөөр нэмэгджээ. Тайлант онд 121.8 сая төгрөгийн бараа материал худалдан авч үйл ажиллагаандаа 90.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,096.6 сая төгрөг болж 167.5 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 38.8 сая төгрөгийг аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 19 өдрийн А/1043 тоот захирамжаар, 2024 оны 10 дугаар сарын 23 өдрийн А/945 тоот захирамжаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнээс эрх шилжүүлэх зарим төсөл, арга хэмжээнээс 8.0 сая төгрөгийн театрын тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй орлогод хүлээн авсан. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 271 дугаар тогтоолоор Нэгдсэн эмнэлгээс 1.5 сая төгрөгийн орыг балансаас балансад шилжүүлэн авсан. Батлагдсан төсвөөс 37.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдаж авч, Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 сарын 24 өдрийн 275 тоот тогтоолоор 131.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 270.3 сая төгрөг өөрчлөлт ороогүй байна. Энэ нь он дамжсан халаалтын зардлын өглөг бөгөөд халаалтын зардлын төсвийн төлөвлөлттэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,826.3 сая төгрөг болж 167.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 167.5 сая төгрөг гарсантай холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 3,222.8 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 982.3 сая төгрөгөөр буюу 43.8 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Өмнөх оноос улсын төсвийн санхүүжилт, орон нутгийн төсвийн санхүүжилт нэмэгдсэн байна. Улсын төсвийн санхүүжилт өмнөх оноос 471.6 сая төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилт 167.2 сая төгрөгөөр, ЗДНХ түүнтэй адилтгах нөөц хөрөнгөөс тухайн төсвийн шууд захирагчид хуваарилсан 3.7 сая төгрөгөө нэмэгдсэн байна.

Нийт зардал өмнөх оноос 581.7 сая төгрөгөөр буюу 23.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал, байр ашиглахтай холбоотой зардал, хангамж, бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, дотоод томилолтын зардлууд байна. Үндсэн болон нэмэгдэл цалин хөлс, байр ашиглахтай холбоотой зардал, хангамж, бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, өмнөх оноос нэмэгдэж, Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлууд өмнөх оноос буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,523.7 сая төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 749.1 сая төгрөгөөр нийт зарлагыг 3,272.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж төсвийн төслийн саналаас улсын төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэрийг 280.5 сая төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 120.9 сая төгрөгөөр нийт зарлагыг 401.4 сая төгрөгөөр хасаж, 2871.4 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдээгүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 2,166.4 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 76.8 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 624.6 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,166.4 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 624.7 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 76.8 сая төгрөгийн орлого оруулсан байна. Үндсэн үйл ажиллагааны орлогоос 66.2 сая төгрөгийн орлого оруулж, Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 6.9 сая төгрөгийн, Соёл урлагийн газраас 3.7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг үндсэн дансаар хүлээн авч зарцуулан, төсвийн гүйцэтгэлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,870.7 сая төгрөг буюу 99.4 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,003,043.5	1,997,468.0	5,575.4	99.72%
80214	Уран бүтээл хийлгэх	40,189.7	36,529.2	1,966.5	90.89%
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	69,586.1	69,391.3	194.7	99.72%
81855	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	53,903.0	52,917.5	6,855.6	88.53%
83603	Дээд шатны төсвөөс хуваарилсан	93,531.1	89,747.6	783.4	99.13%
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	628,151.0	624,653.8	3,497.2	99.44%
	Дүн	2,888,404.4	2,870,707.5	17,696.9	99.38 %

Үндсэн үйл ажиллагааны хөтөлбөрөөс 14.5 сая төгрөгийг, уран бүтээл хийлгэх хөтөлбөрөөс 3.6 сая төгрөгийг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал хөтөлбөрөөс 0.1 сая төгрөг, гүйцэтгэлд суурилсан санхүүжилт хөтөлбөрөөс 6.8 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүү-нийцлийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Хөгжимт драмын театр нь ахмадын сангийн харилцах данс нээлгээгүй, Ахмад настны тухай хуулийн 14.7 дахь заалтыг дагаж мөрдөөгүй байна.

Хөгжимт драмын театр нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаж ажиллаагүй байна. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардал дансаар 4.8 сая төгрөгийн зардлыг ажилтнуудад шинэ уран бүтээлийн мөнгө гэж олгосонд зөрчлийг арилгуулах албан шаардлага өгсөн.

Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулан авч хянаж үзэхэд Соёлын яамнаас орон тооны дээд хязгаарыг 71-ээр баталсан ба гүйцэтгэлээр 73 ажилтантай буюу 2 орон тоогоор илүү байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хөгжимт драмын театр нь нэмэлт санхүүжилт аваагүй, түрээсийн орлого 0.2 сая төгрөг буруу орсныг эхний үлдэгдэл 0.04 сая төгрөг нийт 0.2 сая төгрөгийг үндсэн данс руу төвлөрүүлсэн байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хөгжимт драмын театр нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төсвийн хөрөнгөөр “Мармара Өлгий” ХХК, “Ай ел нур” ХХК-аас 11.8 сая төгрөгийн тавилга, эд хогшил, “Ходллинг оул” ХХК, “Муза интертаймент” ХХК, “Кактус пэй” ХХК-аас 25.5 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авсан байна

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу аймгийн Хөгжимт драмын театрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ш.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөгжимт драмын театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 04 дугаартай албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 613.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 25.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,056.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 45.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 32.1 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон болно.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг тухайн байгууллагад хамааралтай эрсдэлүүдээр шалгаж үзлээ.2024 оны 9 дүгээр сард 9.9 сая төгрөгийн тавилга эд хогшлыг цахим дэлгүүрээс бусад газраас худалдан авч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: *Төрийн цахим худалдан авлтын журмыг хэрэгжүүлж ажиллахыг албан шаардлага болгов.*

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгав.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 9.9 сая төгрөгийн 1, орлогын 10.0 сая төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 99.1 хувьтай байна. Орлогын 29 гүйлгээний 1,104.1 сая төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, хугацаа хоцролтын хэрэгжилтийн хувь 88.2% байна.Шилэн дансны хууль тогтоомжийн бүрэн хэрэгжүүлж ажиллахыг анхааруулав.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөвлөмж, албан шаардлага өгөгдөөгүй, төлбөрийн акт тогтоогоогүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн ангилал, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлыг анхаарах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 137.3 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 0.8 сая төгрөгийн алдааг залрууллаа. *Залруулсан алдаа:*

- Байгууллагын дарга нь Улаанбаатар хотод сургалт семинарт оролцохоор 0.8 сая төгрөгөөр онгоцны 2 талын тийз захиалж, томилолтын зардлаас шилжүүлсэн боловч сургалт, семинар хойшлогдсоноос томилолтоор яваагүй, зардалд хаасныг авлагаар залруулав.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”, УСНББОУС 1 стандарт, толилуулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар нийт 2.4 сая төгрөгийн зөрчилд² төлбөрийн 1 акт тогтоов.

1. Хөгжимт драмын театрын даргын 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн Б/13, Б/14 дүгээр тушаалаар сахилгын шийтгэл оногдуулсан ажилтан М.Ертай, Х.Нурлан нарын сахилгын шийтгэлийг 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн Б/39 дугаар тушаалаар хүчингүй болгож, 2024 оны 3, 4 дүгээр улирлын ажлын үр дүнгийн урамшуулалд 2.5 сая төгрөгийг хууль бус олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан журмын 3 дугаар хавсралтын 2.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно”, 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр барагдуулах акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар нийт 16.2 сая төгрөгийн зөрчилд³ 3 албан шаардлага хүргүүлэв.

1. Аймгийн Хөгжимт драмын театрын дарга, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга нарын 2014 онд гарын үсэг зурж баталсан Хөгжимт драмын театрын тайзны уран бүтээлийн нормчлол, үнэлгээ ба шагнал олгох журам, Уран бүтээлд олгох шагналын хэмжээг үндэслэн бусад ажил үйлчилгээ төлбөр хураамжийн зардлаас 2024 оны 12 дугаар сард 4.7 сая төгрөгийг нэр бүхий ажилтнуудад шинэ уран бүтээлийн мөнгө гэж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн ухай хуулийн 15 дугаар зүйл "Хэмнэлтийн бусад арга хэмжээ", 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагч нарт хууль тогтоомж зөрчиж шинэ уран бүтээлийн мөнгө гэж зардал гаргахгүй байхыг албан шаардлага болгов.

2. Хөгжимт драмын театрын даргын 2024 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн А/24 дугаар тушаалаар нягтлан бодогч А.Манарбект 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан гэж 1.4 сая төгрөгийн урамшуулал олгож, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны "Журам батлах тухай" 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшууллыг холбогдох хууль, журам зөрчиж тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн олгохгүй байхыг албан шаардлага болгов.

3. Тайлант онд худалдан авах ажиллагааг төлөвлөж ажиллаагүй, 9.9 сая төгрөгийн тавилга, эд хогшлыг шууд гэрээгээр худалдан авч цахим худалдан авалтын журмыг зөрчсөн байна

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.13-т "Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

төлөвлөж зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаж, цахим худалдан авалтын журмыг хэрэгжүүлж ажиллахыг албан шаардлага болгов.

5.3 Зөвлөмж

Аудитаар нийт 168,7 сая төгрөгийн зөрчил⁴ илэрч, 149.8 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн Түүхт соёлын дурсгалт зүйл дансанд 1970 оноос 2019 оны хооронд худалдан авсан 1115 нэр төрлийн нийт 73.6 сая төгрөгийн элэгдэж хуучирсан, ашиглах боломжгүй болсон хувцас хэрэглэлийг бүртгэж, тайлагнаж ирсэн бөгөөд эдгээр хөрөнгүүдийг акталж данснаас хасах асуудлыг шийдвэрлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, 4.1.3-д “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, 4.4-д “Энэ хуулийн 4.1.3-т заасан стандартыг Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө”, 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 5.1.5-д “хэмжигдэхүйц байх” гэсэн заалт, Сангийн сайдын 2023 оны А/229 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 10 дугаар бүлгийн 10.1, 10.2, 10.3, 10.4 дүгээрт заалт болон санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, ангилал, толилуулга, оршин байх, батламж мэдэгдлийн хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

- Түүхт соёлын дурсгалт зүйл дансанд бүртгэлтэй дээрх 1115 нэр төрлийн 73.6 сая төгрөгийн хувцсыг байгууллагын Өмч хамгаалах зөвлөлөөр дүгнэлт гаргуулж холбогдох газруудад актлах санал хүргүүлэн, данс бүртгэлээс хасах арга хэмжээ авах, хөрөнгийг зөв ангилж бүртгэх;

2. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

- Хөгжимт драмын театрын үйл ажиллагааны орлогыг кассаар бэлэн хүлээн авахдаа нийт 44.2 сая төгрөгийн орлогыг төсвийн харилцах дансанд тухай бүр хугацаандаа тушаахгүйгээр төсөвт байгууллагын кассын журмыг зөрчсөн байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын

⁴ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана”, 3.12-т “Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын (зарагдсан тасалбараас өөрт үлдэх хувь) тооцоог гаргаж, тайланг тушаана” гэсэн заалтыг зөрчиж байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

- Үйл ажиллагааны орлогыг кассаар бэлнээр хүлээн авахдаа Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын дагуу төсвийн харилцах дансанд тухай бүр тушааж, ажиллах, дотоод хяналтыг сайжруулах;

3.Батлагдсан орон тооны хязгаарын дагуу хүний нөөцийг ажиллуулахтай холбоотой асуудал

3.1.Илрүүлэлт:

Соёлын яамнаас тус театрын 2024 оны төсөвт орон тооны дээд хязгаарыг 71 буюу удирдах 1, гүйцэтгэх 57, үйлчлэх ажилтан 13 байхаар баталсан байна.Гүйцэтгэлээр 73 ажилтан буюу гүйцэтгэх 2 орон тоог батлагдсан орон тооны хязгаараас илүү ажиллуулж, төсвөөс 32.0 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.3-т “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалтыг зөрчиж байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

- Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16.5.3 дахь заалтуудыг мөрдөж орон тооны хязгаарыг мөрдөж ажиллах;

Дээрх аудитын шийдвэрүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмж, албан шаардлага, актын төлбөрийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг үнэн зөв тайлагнаагүй	1	810.1	1	810.1			1	810.1				
Дүн	1	810.1	1	810.1			1	810.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хууль журам зөрчиж олгосон үр дүнгийн урамшуулал	2	3,886.8	1	2,416.8	1	1,470.0	-	-				
Кассын ажиллагаатай холбоотой асуудал	1	44,216.8	-	-	-	-	1	44,216.8				
Хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал	1	73,609.6	-	-	-	-	1	73,609.6				
Батлагдсан орон тооны дээд хязгаарыг хэтрүүлсэн	1	32,048.3					1	32,048.3				
Бусад зардалтай холбоотой асуудал	1	4,760.0	-	-	1	4,760.0	-	-				
Дүн	6	158,521.5	1	2,416.8	2	6230.0	3	149,874.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн тухай хэрэгжилттэй холбоотой асуудал	1	8,845.9	-	-	-	-	1	8,845.9
Дүн	1	8,845.9		--	-	-	1	8,845.9
Нийт дүн	1	8,845.9			-	-	1	8,845.9